

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXV • 2022 • № 3

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Адрес учредителя: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18, лит. А
Адрес редакции: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18, лит. А
Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Свидетельство о регистрации
средства массовой информации
ПИ № ФС77-79202
от 22 сентября 2020 г.
Выдано Федеральной службой
по надзору в сфере связи,
информационных технологий
и массовых коммуникаций
(Роскомнадзор)

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,
доктор филологических наук (Россия)*
Д. А. Носов, *секретарь, кандидат филологических наук
(Россия)*
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор
РАН (Россия)*
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поп, *доктор наук (Румыния)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, про-
фессор (Россия)*
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 22.09.2022

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,

Адрес типографии: 191040. Санкт-Петербург. Пушкинская ул., 4.

e-mail: editor@isvov.ru

ISSN 2311-5939

DOI 10.25882/2xm5-dr90

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2022

© Коллектив авторов, 2022

В НОМЕРЕ:

ЛИНГВИСТИКА	5
D. Zayabaatar. The loss of the consonant <i>-l-</i> and syllable <i>-la/le-</i> in Mongolian	5
ЛИТЕРАТУРОВЕДЕНИЕ И ТЕКСТОЛОГИЯ	17
А. А. Бердыева. Влияние западных литературно-философских тенденций на современную литературу Республики Корея.....	17
Н. В. Ямпольская. К вопросу о структуре монгольских рукописных Ганджуров XVII века: тома <i>ga</i> и <i>da</i> раздела «Сутры» в списках из Аблай-хита	24
ФОЛЬКЛОР И ЭТНОГРАФИЯ	41
А. Алимаа. Халх монголчуудын хүүхдийн сэвлэг үргээх ёслолын соёлын утга өнөө цагийн байдал	41
Б. Х. Борлыкова, Б. В. Меняев. Калмыцкие песни, посвященные ойратской знати.....	51
Г. Бямбарагчаа. Монгольская игра в бабки на льду	61
СМЕЖНЫЕ ДИСЦИПЛИНЫ	67
Ю. А. Иоаннесян. Гератский предлог <i>ta(y)-ye / tey-ye</i> : фонетическая трансформация или контаминация двух предлогов?.....	67
Н. Е. Васильева. Изучение рукописи «Маджмӯ‘ ат-таварйх» и ее значение для исторической этнографии народов Средней Азии	74
НАУЧНАЯ ЖИЗНЬ	84
О. Н. Полянская. Международная научная конференция «Банзаровские чтения», посвященная 200-летию Доржи Банзарова и 90-летию БГПИ — БГУ (Россия, Улан-Удэ, 30-31 марта 2022 г.).....	84
Ц. Ц. Саранцацрал. “Репиний академийн шадар 3” тусгай үзэсгэлэн	89
И. В. Кульганек. Новые книги по монголоведению	92

Цэрэнчимэдийн Саранцацрал
Монгол улсын их сургууль

“РЕПИНИЙ АКАДЕМИЙН ШАДАР 3” ТУСТАЙ ҮЗЭСГЭЛЭН

Об авторе: Саранцацрал Ц. – доктор филологических наук, профессор, Монгольский Государственный Университет, почётный профессор Московского Государственного Университета им. М. В. Ломоносова (Монголия, 14200, Улаанбаатар хот, Сухбаатар дуурэг, Бага тойруу, Их сургуулийн гудамж, 1) ORCID 0000-0001-6804-3013 (ts.sarantsatsral@gmail.com).

About the autor: Ts. SARANTSATSRAL — Dr. Sc. (Philology), Professor. Mongolian State University, Honorary Professor of the Moscow State University after M.V. Lomonosov (Ikh surguuliin gudamj, 1, Baga toiruu, Sukhbaatar duureg Ulaanbaatar, 14201, Mongolia) ORCID 0000-0001-6804-3013 (ts.sarantsatsral@gmail.com).


© ИВР РАН, 2022

© Саранцацрал Ц, 2022

Монгол Арт галерейгаас санаачлан Монголын Урчуудын Эвлэлийн 80 жилийн ойг тохиолдуулан 2022 оны 5-р сарын 25-наас өдрүүдэд Улаанбаатар хотноо “Репиний академийн шадар 3” тусгай үзэсгэлэнг өргөн олон нийтэд дэлгэн барив. Үзэсгэлэнгийн нээлтэнд зураачдын гэр бүл, үр хүүхдүүд, оюутан цагийн анд нөхөд, шавь нар, Улаанбаатар хот дахь “Русский дом”-ын захирал, ОХУ-ын ЭСЯ-ны хэвлэл мэдээлийн атташе, уран бүтээлийг нь бишрэн шүтэгчид нь ирсэн байв.

Энэхүү үзэсгэлэн нь монголын уран зургийн 1970-1990 оны нэрт төлөөлөгч Монгол Улсын төрийн шагналт зураач Батцэндийн Пүрэвсүх, зураач Сэнгэравдангийн Элбэгдорж, МУЭ-ийн шагналт зураач Ёндонгийн Өлзийхутаг нарын дурсгалд зориулсан юм. Хөгжим бүжгийн дунд сургуулийн уран зургийн ангийг 10 хүүхэд төгссөнөөс Б. Пүрэвсүх, Ё. Өлзийхутаг, С. Элбэгдорж нар огт салаагүй. Цаг үргэлж хамтдаа явдаг тэднийг нөхөд нь “Хамтын 3” гэдэг байж. “Хамтын 3” сургуулиа төгсөөд Урчуудын эвлэлийн Улаанбаатар хотын салбарт хамтдаа очиж, дараа нь дэлхийн шилдэг уран бүтээлчдийг төрүүлдэг алдарт Репиний академид 1971–1977 онд сурч, Б. Пүрэвсүх ардын зураач В. М. Орешниковын, Ё. Өлзийхутаг, С. Элбэгдорж нар ЗХУ-ын

ардын зураач Е. Е. Моисеенкогийн урланд тус тус суралцаж төгссөн түүхтэй. Тэд өөр өөрийн уран бүтээлийн замаар явсан ч найз нөхдийн харилцаагаа таслаагүй юм.



«Репиний академийн шадар 3» тусгай үзэсгэлэн



«Репиний академийн шадар 3» үзэсгэлэнгийн нээлт

И. Е. Репиний академийг Монголоос төгсөгчдийн анхдагч нь Ардын зураач Л. Гаваа. Түүний гаргасан энэхүү замаар 70 гаруй монгол уран бүтээлч замнасны гурав нь Б. Пүрэвсүх, С. Элбэгдорж, Ё. Өлзийхутаг нар юм. Хэн хэн нь хорвоод богинохон насалсан ч хосгүй бүтээлүүдийг Монголын дүрслэх урлагт тамгалж, уран зургийн хөгжилд өрнийн соёлыг нэвтрүүлж чадсан гайхалтай уран бүтээлчид билээ.

Б. Пүрэвсүх агсны хувьд түүхэн сэдэвт уран зургийн гол төлөөлөгч, киноны зургийн мастер. “Мандухай цэцэн хатан”, “Мөнх тэнгэрийн хүчин дор” киноны ерөнхий зураачаар ажилласан. Түүний уран бүтээлийн онцлог, зурах арга барилын талаар ДУА-ийн уран зургийн багш Г. Лхагвасүрэн “Тэрбээр бүтээл бүртээ өнгө зохиомжийн хөг нийлсэн сүрлэг дайчин давшин-

гүй хөдөлгөөнт шийдлээр түүхэн үйл явдлын эгзэгтэй хором агшныг оновчтой сонгож цаг хугацаа орон зайн нөхцөлд түүхэн бодит хүмүүсийн эх оронч, тэмцэлд уриалан дуудагч дүрийг харуулж чаддаг. Энэ нь түүний уран зурагт мэргэшсэн их мастер уран чадвар түүхийн үнэ цэнийг эрхшээсэн чинад сэтгэлийн нь илрэл болдог юм” хэмээн онцолжээ.

Харин Орос, Европын уран зургийн уламжлалт аргыг гайхалтай эзэмшсэн зураач С. Элбэгдоржийн хувьд Монголын дүрслэх урлагийн сан хөмрөгт “Ард Аюуш”, “Их ялалтын эхэн”, “Хот айл” зэрэг томоохон бүтээлийг үлдээсэн юм. Тэрбээр хөрөг зургийн мастеруудын нэг байжээ. Үнэхээр ч түүний олонд алдаршсан “Эрдэмтэн зохиолч Ц. Дамдинсүрэн”, “Зураач-багш О. Цэвэгжав”, “Зураач-багш Б. Чогсом”, “Миний төрсөн нутаг” (“Өөрийн хөрөг”) зэрэг



Өлзийхутаг Унага тамгаласан нь



Пүрэвсүх Анхны галт тэрэг



С. Элбэгдорж Шинэ хотын зүг

хөргүүд нь нь дүрийнхээ гадаад төрхийг төдийгүй, оюун санааны ертөнц, зан чанарыг нь илэрхийлж чадсан бөгөөд хоорондоо эрс ялгаатай, онцлог арга барил бүхий бүтээлүүд нь өдгөө ч судлаачдын анхаарлыг татсаар.

Харин Монголын уран зургийн сод бүтээлийн сан хөмрөгт Ё. Өлзийхутагийн хэд хэдэн том бүтээл бий. Тэдгээрээс хамгийн алдартай нь 1982 онд зотон дээр тосон будгаар урласан “Талын эзэд” зураг юм. 160x160 см хэмжээтэй энэ бүтээлдээ Монголын эр зоригт, эрэлхэг хүчит дайчин эрсийн үргэлжлэл болсон хөдөө нутгийн адуучин залуусыг зохиомжийн төвд бүтнээр нь дүрсэлжээ. Ё. Өлзийхутаг агсан мөн л хөрөг зургийн чадварлаг мастер байсныг “Охин”, “Хүү Цэлмэн” зэрэг олон зургаас харж болно.

Б. Пүрэвсүх, С. Элбэгдорж нар нь уран бүтээлээ туурвихын зэрэгцээ Дүрслэх урлагийн дунд сургуульд уран зургийн багшаар ажиллаж авьяаслаг олон зураачдыг сургаж бэлтгэсэн гавъяатай.

Үзэсгэлэнд зураачдын уран бүтээлүүдээс гадна сонирхол татсан зүйл олон байв. Тухайлбал: Монгол Арт галерейн зүгээс нэрт гурван зураачийн амьдрал, уран бүтээлээс харуулсан богино хэмжээний баримтат кино бүтээсэн нь үзэгчдийн сэтгэлийг ихэд хөдөлгөж байлаа. Б. Пүрэвсүх, Ё. Өлзийхутаг, С. Элбэгдорж нарын хэрэглэж явсан молберт, этюдникийг хүндэтгэлийн хэсэгт байрлуулсан байв. И.Репиний академийн ректор Михайловский С.И., гадаад оюутан хариуцсан декан Бекетов К.А. нар цахи-

маар видео мэндчилгээ хүргэж байсан нь дотно сайхан сэтгэгдэл төрүүллээ. ОХУ-ын Дүрслэх урлагийн академийн архив (РАХ)-аас хүлээн авсан Б. Пүрэвсүх, Ё. Өлзийхутаг, С. Элбэгдорж нарын 1977 онд Репиний академи төгсөхдөө бүтээсэн дипломын ажлуудын эх, хувийн хэрэг зэрэг архивын ховор материалуудын гэрэл зургуудыг дэлгэн үзүүлсэн байв. Шилэн хоргонд Репиний академийн диплом, үнэмлэх, шагналууд зэрэг ховор нандин түүхийн материалууд ч олны сонирхолыг татаж байлаа. Эдгээрийн дотор “Зөвлөлтийн ардын зураач, профессор Е. Е. Моисеенко өөрийн шавь С. Элбэгдорждоо бичиж дурсгасан гайхамшигт үгсийн шидэт энерги онцгой сэтгэгдэл төрүүлвэй” хэмээгээд “энэхүү үзэсгэлэн сайхь гурван анд уран зураачийн дотоод сэтгэлийн ертөнц, мэдрэмж, ур чадварын илэрхийлэл болсон хосгүй бүтээлүүдийн дээжээс ард түмэндээ танилцуулж, дурсан санаж, алдар гавъяаг нь мөнхлөхөд зориулагдсан мэт санагдсан билээ” гэж Репиний академийн 1993 оны төгсөгч, ЗХУ-ын хөдөлмөрийн баатар, уран барималч, профессор М. К. Аникушины урланд суралцаж төгссөн урлаг судлалын ухааны доктор, профессор С. Бадрал сэтгэгдлээсээ хуваалцав.

Цаг үргэлж судалбар, таталбар хийж усан будаг болон тосон будаг, нүүрс харандаагаар чадварлаг ажилладаг байсны баталгаа болсон олон бүтээл нь эзэн нь үгүй ч мөнх амьдарч байна. Ийм л түүх, урын сантай эрхэм гурван зураачийн бүтээлүүдийг түгээх, сурталчилах, авьяаслаг уран бүтээлчдээ дурссан “Репиний академийн шадар 3” үзэсгэлэн инээд хөөр, баяр баясал хааяахан хайрт ханиа, эрхэм аавыгаа санагалзах гунигийн нулимстайгаар сэтгэл догдлом болж өндөрлөсөн юм.

Монгол Арт галерей, зураачдын гэр, үр хүүхдүүд үзэсгэлэнг зохион байгуулахад хамтран ажилласан дотоод гадаадын байгууллага, хамт олон, хувь хүн ялангуяа Санкт-Петербург хот дахь Оросын Дүрслэх урлагийн академийн архив (РАХ)-ын эрдэм шинжилгээний тасгийн хамт олон, Илья Репиний нэрэмжит дүрслэх урлагийн академийн удирдлага, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн ажилтан нарт гүн талархал илэрхийлж байна.